

## БАНК БУС САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЖУРАМ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-ноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, банк бус санхүүгийн байгууллага /цаашид ББСБ гэх/, түүний салбар байгуулах, нэмэлт үйл ажиллагаа эрхлэх, ББСБ-ын дүрмийн сангийн бүтэц, хэмжээнд өөрчлөлт оруулах, оноосон нэр солих зөвшөөрөл олгох, олгосон тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох болон бусад зохицуулалтын асуудалтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Банк бус санхүүгийн үйл ажиллагаанд Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7.1-д заасан зээл, факторингийн үйлчилгээ, санхүүгийн түрээс, төлбөрийн баталгаа гаргах, төлбөр тооцооны хэрэгсэл гаргах, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, гадаад валютын арилжаа, итгэлцлийн үйлчилгээ, богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх үйл ажиллагаа хамаарна.

1.3. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Хорооноос авсан хуулийн этгээдийг “Банк бус санхүүгийн байгууллага /ББСБ/” гэнэ.

1.4. Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ гэж Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу гадаадын иргэн, хуулийн этгээдтэй хамтарсан буюу гадаадын иргэн, хуулийн этгээдийн хөрөнгөөр Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байгуулагдсан ББСБ, Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа ББСБ-ын хувьцааг гадаадын хөрөнгө оруулагч худалдан авсан ББСБ-ыг хэлнэ.

1.5. Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол Хороо нь банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохдоо тухайн ББСБ-ын дүрмийн сангийн өмчлөл, үүсгэн байгуулагдсан хэлбэр, эрхлэх үйл ажиллагааны төрлөөс үл хамааран хууль, журамд заасан шаардлага зарчмыг адил тэгш баримтлана. Шаардлагатай гэж үзвэл, Хороо банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх, актив пассив хөрөнгө, бусад зүйлд тусгайлан шаардлага тавьж, хязгаарлалт хийж болно.

1.6. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу төсвөөс санхүүждэг хуулийн этгээд, шашны болон төрийн бус байгууллага, энэрэнгүй үйлсийн сангаас ББСБ-ын дүрмийн санд хувь хөрөнгө оруулах, хувьцааг нь худалдаж авахыг хориглоно.

### ХОЁР. БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА БАЙГУУЛАХАД ТАВИГДАХ ШААРДЛАГА

2.1. ББСБ-ыг Компанийн тухай хуулийн 13, 18 дугаар зүйлд заасны дагуу хувь нийлүүлэх, хувьцаа гаргах, хувьцааны захиалга авах аргаар болон өөрчлөн байгуулах /нийлэх, нэгдэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх/ замаар, хувьцаат компани (цаашид ХК гэх) болон хязгаарлагдмал хариуцлагатай компани (цаашид ХХК гэх) хэлбэрээр байгуулж болно.

2.2. Банк бус санхүүгийн байгууллагыг ХК хэлбэрээр байгуулах тохиолдолд энэ журмын 2.3-д заасан бичиг баримтуудыг бүрдүүлж Хороонд ирүүлж, Хороо тусгай

---

зөвшөөрөл олгохоор шийдвэрлэсний дараа Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5-9 дүгээр зүйлийн дагуу үнэт цаасаа Хороонд бүртгүүлж, нийтэд санал болгон арилжаална.

2.3.ББСБ үүсгэн байгуулж, банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн дотоод, гадаадын иргэн, хуулийн этгээд нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11.1, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 8, 10 дугаар зүйл болон энэхүү журмын шаардлагыг хангасан дор дурдсан баримт бичгийг Хороонд ирүүлнэ. Үүнд:

2.3.1.Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохыг хүссэн өргөдлийг энэхүү журмын нэгдүгээр хавсралтын дагуу гаргана.

2.3.2.Үндэсний татварын ерөнхий газрын Улсын бүртгэлийн албанаас авсан ББСБ-ын оноосон нэрийн зөвшөөрлийн тодорхойлолт.

2.3.3.ББСБ-ыг нэгээс дээш үүсгэн байгуулагч нийлж үүсгэн байгуулж байгаа бол ББСБ байгуулж, банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тухай хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрийн эх хувь, эсвэл нотариатаар баталгаажуулсан хуулбар.

2.3.4.ББСБ нь үүсгэн байгуулагчдын хурлаараа баталсан үйл ажиллагаандаа мөрдөх дүрэм, заавар, журам болон бусад зохицуулалтын баримт бичгүүдийн эх хувь эсвэл нотариатаар баталгаажуулсан хуулбар.

2.3.5.Нотариатаар баталгаажуулсан ББСБ-ын дүрэмд дараах зүйлийг тусгана:

2.3.5.1.Компанийн тухай хуулийн 16.2-д заасан зүйл;

2.3.5.2.Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 10.1-д заасан зүйл;

2.3.5.3.дүрмийн сангийн бүтцэд өөрчлөлт оруулах нөхцөл;

2.3.5.4.ББСБ-ын Хувь нийлүүлэгчдийн хурал хуралдах журам, ББСБ их хэмжээний болон ашиг сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхэд баримтлах журам, энэ талаарх удирдлагын бүрэн эрх;

2.3.5.5.хувь нийлүүлэгчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, хянан шалгах зөвлөл, дотоод хяналтын нэгжийн бүрэн эрх, үүрэг, хариуцлага;

2.3.5.6.хувьцааг арилжих, бусдад шилжүүлэх, харилцан хязгаарлалт хийх үйл ажиллагааг зохицуулах хууль зүйн үндэслэл, хууль тогтоомжид заасан бусад асуудал;

2.3.5.7.ББСБ татан буугдах үндэслэл, ББСБ-ын удирдлагын буруутай үйл ажиллагаанаас иргэд, харилцагчдад учруулсан хохирлыг барагдуулах арга хэлбэр, хариуцлага хүлээх зарчим.

2.3.6.Хорооноос тогтоосон ББСБ-ын дүрмийн сангийн доод хэмжээнд хүрсэн хувь нийлүүлэгч нарын оруулсан дүрмийн сангийн мөнгөн хөрөнгийн эх үүсвэр нь хууль ёсны орлогоос бүрдсэн болохыг нотлох баримт бичиг, гарал үүслийн талаарх тодорхойлолтуудыг ирүүлнэ.

---

2.3.7. Мөнгө угаах, алан хядах ажиллагааг санхүүжүүлэхийн эсрэг арга хэмжээний тухай хууль тогтоомжид заасан бусад мэдээлэл, тодорхойлолт.

2.3.8. ББСБ-ын дүрмийн санг бүрдүүлсэн мөнгөн хөрөнгө, түүнийг банкинд байршуулсан эсэхийг тодорхойлсон банкны тодорхойлолт, бусад баталгаа.

2.3.9. ББСБ-ын хууль тогтоомжид заасан дүрмийн сангийн доод хэмжээг тусгасан эхлэлтийн баланс.

2.3.10. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 13.5, 13.6-д заасан шаардлагыг хангасан хувь нийлүүлэгч, ТУЗ-ийн дарга, гишүүд энэхүү журмын хоёрдугаар хавсралтын дагуу тодорхойлолтыг гаргаж ирүүлнэ.

2.3.11. Гүйцэтгэх захирал, нэгжийн удирдлага болон боловсон хүчний тодорхойлолтыг энэхүү журмын гуравдугаар хавсралтын дагуу гаргаж ирүүлнэ.

2.3.12. ББСБ-ын дүрмийн сангийн 10 буюу түүнээс дээш хувийг эзэмшдэг үүсгэн байгуулагч, хувь нийлүүлэгч, гүйцэтгэх удирдлага, мэргэжилтнүүдийн талаарх холбогдох байгууллагаас гаргасан дараах тодорхойлолтууд. Үүнд:

а/ татварын байгууллагад өр төлбөртэй эсэх талаарх тодорхойлолт;

б/ ял шийтгэлтэй эсэх талаарх Цагдаагийн ерөнхий газрын тухайн асуудал хариуцсан хэлтэс, тасгийн удирдлагын гарын үсэг бүхий тодорхойлолт.

2.3.13. Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-ын хувьд тухайн орны онцлогоос шалтгаалан энэ журмын 2.3-ын 12а, 12б-д заасан тодорхойлолтуудыг гаргаж ирүүлэх боломжгүй бол гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-ын үүсгэн байгуулагч нар энэ тухай баталгаа гаргаж ирүүлнэ.

2.3.14. Хороо шаардлагатай гэж үзвэл тухайн орны холбогдох байгууллагуудаас лавлагаа авах эрхтэй.

2.3.15. Техник тоног төхөөрөмж, программ хангамж, ажлын байрны тодорхойлолтыг энэ журмын дөрөвдүгээр хавсралтын дагуу үйлдэж, түүнд техник тоног төхөөрөмж, программ хангамж, ажлын байрны найдвартай, аюулгүй ажиллагаа, нууцлал, харуул, хамгаалалтын асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар тусгаж, дурдсан шаардлагын талаар бусад этгээдтэй байгуулсан гэрээ эсхүл нотариатын байгууллагаар баталгаажуулсан гэрээний хуулбарыг ирүүлнэ.

2.3.16. Бизнес төлөвлөгөөг энэ журмын 5 дугаар хавсралтад заасан зөвлөмжийн дагуу боловсруулж ирүүлнэ.

2.4. Гадаадын хөрөнгө оруулагч дангаараа дүрмийн санг эзэмшдэг ББСБ-д дараах шаардлага тавигдана. Үүнд:

2.4.1. Хорооноос тогтоосон дүрмийн сангийн доод хэмжээг хангасан байх;

2.4.2. ажиллах боловсон хүчний 70-аас доошгүй хувийг Монгол улсын иргэдээс бүрдүүлэх;

2.4.3. гүйцэтгэх удирдлага нь гадаадын иргэн байгаа нөхцөлд байнгын мэргэжлийн орчуулагчтай байх;

---

2.4.4. гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ байгуулж, банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахад энэ журмын 2.3-д заасан баримт бичгийг монгол хэл дээр 2 хувь үйлдэж, шаардлагатай бол орчуулсан хувийг нотариатаар гэрчлүүлсэн байна.

2.5. ББСБ-ын үүсгэн байгуулагчаас банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн баримт бичгийг бүрэн гүйцэд, үнэн зөв бүрдүүлж Хороонд ирүүлсэн өдрөөс эхлэн шийдвэрлэх ажлын хоногийн хугацааг тооцно.

2.6. Хэрэв бичиг баримтыг зайлшгүй магадлан шинжлэх, нэмж тодруулах шаардлагатай бол нэмэлт материалыг бүрдүүлж ирүүлсэн өдрийг бичиг баримтыг анх хүлээн авсан өдрөөр тооцно.

2.7. ББСБ нь Хорооноос олгосон тусгай зөвшөөрөл бүхий банк бус санхүүгийн үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш хугацаанд ББСБ байгуулахаар анх бүрдүүлж ирүүлсэн энэхүү журмын 2.3, 2.4-д дурьдсан баримт бичигт өөрчлөлт орох тухай бүрт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг ажлын 10 хоногийн дотор Хороонд ирүүлнэ.

2.8. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсч ирүүлсэн баримт бичиг, холбогдох материалууд нь шаардлага хангасан гэж үзээд Хороо тусгай зөвшөөрөл олгохоор шийдвэрлэсний дараа ББСБ-ын дүрмийн сангийн мөнгөн хөрөнгийг Хорооны дансанд байршуулахыг ББСБ-ын үүсгэн байгуулагчид албан бичгээр мэдэгдэнэ.

2.9. Үүсгэн байгуулагч нь уг албан бичгийг хүлээн авснаас хойш дүрмийн сангийн мөнгөн хөрөнгийг ажлын 3 хоногийн дотор холбогдох дансанд төвлөрүүлж, хуанлийн 10 хоног байршуулах ба энэхүү мөнгөн хөрөнгөнд Хороо хүү төлөхгүй.

### ГУРАВ. БАНК БУС САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, ОЛГОХООС ТАТГАЛЗАХ

3.1. Хороо банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохыг хүсч үүсгэн байгуулагчаас ирүүлсэн баримт бичгийг Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 8-10 дугаар зүйл, энэ журмын холбогдох заалтыг үндэслэн хянаж, шаардлагатай асуудлыг газар дээр нь шалгасны үндсэн дээр тусгай зөвшөөрөл олгоно.

3.2. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох шийдвэрт тухайн ББСБ-д ямар төрлийн банк бус санхүүгийн үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрөл олгосныг тусгана. Хэрэв банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тодорхой хугацаагаар олгож байгаа бол энэ тухай заана.

3.3. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг энгийн болон нэмэлт гэж ангилна. Үүнд:

3.3.1. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны энгийн тусгай зөвшөөрөлд Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 3, 4, 7, 10 (зээл, факторингийн үйлчилгээ, санхүүгийн түрээс, төлбөрийн баталгаа гаргах, гадаад валютын арилжаа, хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх)-т заасан үйл ажиллагаа хамаарна.

3.3.2. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны нэмэлт тусгай зөвшөөрөлд Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, 6, 8, 9 (төлбөр тооцооны хэрэгсэл гаргах, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, итгэлцлийн үйлчилгээ, богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө

---

*оруулалт хийх*)-т заасан үйл ажиллагаа хамаарна.

3.4.ББСБ-д итгэлцлийн үйл ажиллагаа нэмж эрхлэх зөвшөөрөл олгохдоо Хорооноос баталсан Итгэлцлийн үйл ажиллагааг зохицуулах тухай журмыг мөрдөнө.

3.5.ББСБ-д банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохдоо эхний ээлжинд энэхүү журмын 3.3.1-т заасан банк бус санхүүгийн үйл ажиллагааны зарим төрлийг эрхлэх тусгай зөвшөөрлийг олгоно.

3.6.Энэхүү журмын 3.2-д заасны дагуу гаргасан Хорооны шийдвэр болон Хорооноос баталсан Тусгай зөвшөөрлийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг тогтоох тухай журамд зааснаар холбогдох хураамжийг Хорооны дансанд төлсөн баримтыг үндэслэн тухайн ББСБ-д банк бус санхүүгийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн гэрчилгээг олгоно.

3.7.Хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгогдсон ББСБ-ын гүйцэтгэх удирдлага Хорооны хяналтанд байх түр дансанд байршуулсан ББСБ-ын дүрмийн сангийн мөнгөн хөрөнгийг өөрийн харилцах дансанд шилжүүлэх тухай хүсэлтээ албан ёсоор Хороонд тавина.

3.8.Хороо тухайн ББСБ-ын тусгай зөвшөөрлийг бүртгэн авч, зохих зааврын дагуу нэгдсэн бүртгэлд бүртгэнэ.

3.9.ББСБ нь Хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан тухай Улсын бүртгэлийн албанд бүртгүүлснээр үйл ажиллагаагаа эхэлнэ.

3.10.Хороо дараах үндэслэлээр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохоос татгалзана.Үүнд:

3.10.1.Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 9.1-д заасан шаардлагыг хангаагүй;

3.10.2.хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь нотлогдсон.

3.11.Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд Хороо энэ талаарх үндэслэл бүхий тайлбарыг өргөдөл гаргагчид албан бичгээр мэдэгдэнэ.

3.12.Хуурамч баримт бичиг бүрдүүлсэн гэдэг үндэслэлээр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохоос Хороо татгалзсан тохиолдолд татгалзсан өдрөөс хойш 1 жилийн дотор ББСБ-ын хувь нийлүүлэгчид гүйцэтгэх удирдлагад ажиллах этгээдүүдээс банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн хүсэлтийг дахин хүлээж авахгүй.

3.13.ББСБ нь Хорооноос тавьсан болон холбогдох хууль журамд заасан шаардлагыг бүрэн хангасан гэж үзвэл, дээр зааснаас бусад тохиолдолд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсч Хороонд дахин тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргаж болох бөгөөд Хорооноос баталсан Тусгай зөвшөөрлийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг тогтоох тухай журамд зааснаар холбогдох хураамжийг дахин шинээр төлнө.

---

**ДӨРӨВ. БАНК БУС САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭНГИЙН  
БОЛОН НЭМЭЛТ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ НЭМЖ ОЛГОХ**

4.1.Энэхүү журмын 3.3.1-т заасан банк бус санхүүгийн үйл ажиллагааны энгийн тусгай зөвшөөрлийг дараах шалгуурыг хангасан банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-д нэмж олгож болно. Үүнд:

4.1.1.Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, бусад холбогдох хууль, журамд заасан шаардлагыг бүрэн хангасан;

4.1.2.Хорооноос баталсан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг 6 сараас дээш хугацаанд хангаж, үйл ажиллагаагаа хэвийн явуулсан.

4.2.Энэхүү журмын 3.3.2-т заасан банк бус санхүүгийн үйл ажиллагааны нэмэлт тусгай зөвшөөрлийг дараах шалгуурыг хангасан банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-д олгож болно. Үүнд:

4.2.1.Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, бусад холбогдох хууль, журамд заасан шаардлагыг бүрэн хангасан;

4.2.2.Хорооноос баталсан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж, 9 сараас дээш хугацаанд үйл ажиллагаагаа хэвийн явуулсан;

4.2.3.тухайн ББСБ-ын санхүү, төлбөрийн чадвар, нэр хүнд болон хувь нийлүүлэгчдийн бизнесийн ёс зүй, нэр хүнд нь уг үйл ажиллагааг эрхлэхэд харшлахгүй байх.

4.3.Банк бус санхүүгийн үйл ажиллагааны энгийн болон нэмэлт тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлд нэмж эрхлэх үйл ажиллагааг тусгаж, дараах баримт бичгийн хамт Хороонд ирүүлнэ. Үүнд:

4.3.1.тухайн үйл ажиллагаа эрхлэх талаарх хувь нийлүүлэгчдийн шийдвэр, нэмж шаардагдах өөрийн хөрөнгө, зардал, тэдгээрийн эх үүсвэрийн тооцоо;

4.3.2.ББСБ-ын дүрэмд орох өөрчлөлт;

4.3.3.бизнес төлөвлөгөө болон санхүүгийн тайлангуудад орох өөрчлөлтийн төсөл, танилцуулга;

4.3.4.тухайн үйл ажиллагааг эрхлэхэд мөрдөх бодлогын чанартай эрх зүйн баримт бичиг;

4.3.5.банк бус санхүүгийн нэмэлт тусгай үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүсч буй ББСБ нь дээр дурдсан эрх зүйн баримт бичигт цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, итгэлцлийн үйлчилгээ, богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйлчилгээний нэр төрөл, гүйцэтгэх журам, зохицуулалт, оролцогч талуудын эдлэх эрх, үүрэг, хүлээх хариуцлага, үйл ажиллагааны эрсдлийг тооцох аргачлал зэргийг тодорхой тусгана.

4.4.Хороо энэхүү журмын 4.3-д дурдсан баримт бичгийг хянаж, 3.3.1, 3.3.2-т заасан энгийн болон нэмэлт үйл ажиллагаа эрхлэх нь тухайн ББСБ-ын санхүүгийн чадварт сөргөөр нөлөөлөхгүй, харилцагчдад нь хохирол учруулахгүй гэж үзсэн, боловсон хүчин техник тоног төхөөрөмж программ хангамж нь тухайн үйл ажиллагааг хэвийн явуулах

---

нөхцөлийг хангаж байна гэж үзвэл уг үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөл олгох шийдвэр гаргана.

4.5.Банк бус санхүүгийн үйл ажиллагааны энгийн болон нэмэлт тусгай зөвшөөрөл нэмж олгох тухай Хорооны шийдвэр болон Хорооноос баталсан Тусгай зөвшөөрлийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг тогтоох тухай журамд зааснаар холбогдох хураамжийг Хорооны дансанд төлсөн баримтыг үндэслэн Хороо тухайн ББСБ-ын тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад зохих тэмдэглэгээг хийж, баталгаажуулна.

4.6.Банк бус санхүүгийн үйл ажиллагааны энгийн ба нэмэлт тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсанаас хойш ББСБ-ын хувь нийлүүлэгчдээс банк бус санхүүгийн үйл ажиллагааны энгийн ба нэмэлт тусгай зөвшөөрөл хүссэн хүсэлтийг дахин хүлээж авч болно.

#### ТАВ. БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭГЖ БАЙГУУЛАХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ

5.1.ББСБ-ын салбар, гадаад валютын арилжаа эрхлэх зөвшөөрөлтэй ББСБ-ын хувьд валютын касстай байж болно.

5.2.Гадаад валютын арилжаа эрхлэх зөвшөөрөлтэй ББСБ-ын хувьд валютын касс гэж гадаад валют бэлнээр худалдах, худалдан авах нэгжийг хэлнэ.

5.3.ББСБ-ын нэгж нь зөвхөн тухайн ББСБ-ын оноосон нэрийг хэрэглэнэ.

5.4.ББСБ-ын салбарын эрхлэх үйл ажиллагааны хүрээ, ажиллах журмыг ББСБ өөрөө тогтооно.

5.5.ББСБ нь салбар нээх зөвшөөрлийг Хорооноос авна.

5.6.ББСБ салбар нээх хүсэлт гаргахдаа дараах баримт бичгийг бүрдүүлж, Хороонд ирүүлнэ. Үүнд:

5.6.1.тухайн салбарын үйл ажиллагаа явуулах хүрээ, бүх эрсдлийг ББСБ хариуцах тухай хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэр;

5.6.2.салбарын үйл ажиллагааг зохицуулах тухай болон дотоод хяналтыг зохицуулах тухай журам.

5.7.Хороо энэхүү журмын 5.6-д дурдсан баримт бичгийг хянаж, салбар байгуулах нь тухайн ББСБ-ын санхүүгийн чадварт сөргөөр нөлөөлөхгүй, харилцагчдад нь хохирол учруулахгүй гэж үзсэн, боловсон хүчин, техник тоног төхөөрөмж, программ хангамж нь тухайн салбарын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг хангаж байна гэж үзвэл зөвшөөрөл олгох шийдвэрийг Хорооны дарга гаргана.

5.8.ББСБ-ын салбар, валютын касс нээх, татан буулгах, үйл ажиллагааг хязгаарлах, өөрчлөн байгуулах /нэгтгэх, нийлүүлэх, салгах, тусгаарлах, өөрчлөх/, байршлыг нь өөрчлөх /салбарын байршлыг өөр нэгжид болон өөр хооронд нь солих, шилжүүлэх/ тухай бүрт шийдвэр гаргаж, уг шийдвэрийг гаргасан өдрөөс хойш ажлын 3 хоногийн дотор Хороонд бүртгүүлнэ.

5.9.ББСБ-ын салбар, валютын касстай холбоотой Хорооны даргын шийдвэр болон

---

Хорооноос баталсан Тусгай зөвшөөрлийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг тогтоох тухай журамд зааснаар холбогдох хураамжийг Хорооны дансанд төлсөн баримтыг үндэслэн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад салбар, валютын кассын талаарх тэмдэглэлийг хийж баталгаажуулна.

5.10.Хороо нь тухайн ББСБ-ын салбар Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль тогтоомжид нийцээгүй үйл ажиллагаа явуулсан, Хорооноос болон улсын байцаагчдын бичгээр өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй буюу тухайн нэгжийн үйл ажиллагаа ББСБ-ын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй гэж үзвэл ББСБ-ын нэгжийн үйл ажиллагааг зогсоож болно.

5.11.ББСБ-ын нэгж байгуулах зөвшөөрлийг дараах үндэслэлээр хүчингүй болгож, тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд ажлын 5 хоногийн дотор энэ тухай тэмдэглэл хийнэ. Үүнд:

5.11.1.нэгжийг татан буулгах ББСБ-ын удирдлагын шийдвэр;

5.11.2.нэгжийн үйл ажиллагаа нь тухайн ББСБ-ын хэвийн үйл ажиллагаа, санхүү, төлбөрийн чадварт хүндрэл учруулахаар байгааг тогтоосны үндсэн дээр гаргасан Хорооны даргын шийдвэр;

5.11.3.хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.

5.12.ББСБ-ын хувь нийлүүлэгчдээс ББСБ-ын нэгжийн зөвшөөрлийг хүчингүй болгосон үндэслэлийг арилгаж, зохих шаардлагыг хангасны дараа дахин салбар, валютын касс байгуулах хүсэлтийг Хороо хүлээн авна.

## ЗУРГАА. ДҮРМИЙН САНГИЙН ХЭМЖЭЭ, БҮТЦЭД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХАД ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, БҮРТГЭХ

6.1.ББСБ нь дүрмийн сангийн хэмжээ, бүтцийг дараах байдлаар өөрчилнө. Үүнд:

6.1.1.Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 14.2-т заасны дагуу үүсгэн байгуулагч болон хувь нийлүүлэгчдээс оруулсан мөнгөн хөрөнгөөр;

6.1.2.Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх явцад тухайн жилийнхээ ногдол ашгаас бусад хувь нийлүүлэгчдийн зөвшөөрлийн үндсэн дээр хөрөнгө оруулах, хувьцаа нэмж гаргах, шинээр хувь нийлүүлэгч элсүүлэх.

6.2.Дүрмийн сангийн өөрчлөлтийг тухай бүр Хороонд мэдэгдэж, зөвшөөрөл авч байна. Зөвшөөрлийг авахдаа эдгээр өөрчлөлтийн дагуу аливаа гүйлгээ, төлбөр хийхээс өмнө дараах бичиг баримтыг Хороонд ирүүлнэ. Үүнд:

6.2.1.өргөдөл;

6.2.2.өөрчлөлт оруулах болсон хууль зүйн үндэслэлийг нотлох баримт бичиг;

6.2.3.ББСБ-ын дүрмийн санд хувь нийлүүлэн шинээр орж буй хувь нийлүүлэгч /хувь нийлүүлэгчид/-ийн хувьд энэ журмын 2.3.12-т заасан мэдээллийг холбогдох байгууллагаас авсан тодорхойлолт, дүрмийн санд оруулах хөрөнгө нь хуулиар зөвшөөрөгдсөн үйл ажиллагаанаас олсон орлогоос бүрдэж буйг нотлох баримт бичиг;



---

6.2.4. Мөнгө угаах, алан хядах ажиллагааг санхүүжүүлэхийн эсрэг арга хэмжээний тухай хууль тогтоомжид заасан бусад мэдээлэл, тодорхойлолт;

6.2.5. ББСБ-ын шинэ хувь нийлүүлэгч /хувь нийлүүлэгчид/-ийн талаарх тодорхойлолтыг энэхүү журмын гуравдугаар хавсралтын дагуу гаргах;

6.2.6. Дүрмийн сангийн хэмжээ, бүтцийг өөрчилсөнтэй холбогдуулан ББСБ-ын дүрэмд орох нэмэлт өөрчлөлт (дүрэм өөрчлөгдөх шаардлагатай бол);

6.2.7. ХК хэлбэрээр байгуулагдсан ББСБ-ын хувьд хувьцааны эзэмшигч өөрчлөгдсөн тухай ҮЦТТХТ ХХК-иас ирүүлсэн тодорхойлолт, хувьцаа эзэмшигчийн дансны үлдэгдэл бүхий хуулга.

6.3. Дүрмийн сангийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрөл олгохыг хүсч ББСБ-аас ирүүлсэн хүсэлт, холбогдох баримт бичгийг Хорооны Ажлын алба Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, энэ журмын холбогдох заалтыг үндэслэн хянаж, шаардлагатай асуудлыг газар дээр нь шалгасны үндсэн дээр санал, дүгнэлт гарган Хорооны даргад танилцуулна. Хорооны дарга холбогдох хууль, тогтоомжийг үндэслэн ББСБ-ын дүрмийн сангийн бүтэц, хэмжээнд өөрчлөлт оруулах эсэх талаар эцсийн шийдвэр гаргана.

6.4. Дүрмийн санг хорогдуулах нь ББСБ-ын санхүү, төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлөхгүй, бусад хувь нийлүүлэгч, харилцагчдад хохирол учруулахгүй, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 14.4-д заасан хариуцлагаас зайлсхийсэн гэх үндэслэлгүй гэж Хороо үзвэл дүрмийн санг хорогдуулах зөвшөөрлийг олгоно.

6.5. ББСБ-ын дүрмийн сангийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулахад зөвшөөрөл олгох эсэхийг ажлын 10 хоногийн дотор шийдвэрлэнэ. Энэ журмын 6.2-д заасан баримт бичиг нь зохих шаардлага хангасан гэж үзвэл дүрмийн санг нэмэгдүүлэх мөнгөн хөрөнгийг Хорооны хяналтанд байх дансанд байршуулахыг ББСБ-ын хувь нийлүүлэгчдэд албан бичгээр мэдэгдэнэ.

6.6. Хувь нийлүүлэгчид нь тус албан бичгийг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногийн дотор ББСБ-ын дүрмийн санг нэмэгдүүлсэн мөнгөн хөрөнгийг холбогдох дансанд хуанлийн 10 хоногт байршуулах ба энэхүү мөнгөн хөрөнгөнд Хороо хүү төлөхгүй.

## ДОЛОО. БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ОНООСОН НЭРИЙГ ӨӨРЧЛӨХ

7.1. Тусгай зөвшөөрөл бүхий банк бус санхүүгийн үйл ажиллагаагаа хэвийн явуулж, зохистой харьцааны үзүүлэлтүүдийг ханган ажиллаж буй ББСБ оноосон нэрээ өөрчлөхийг хүсвэл Хороонд өргөдөл гаргах бөгөөд дараах баримт бичгийг бүрдүүлж ирүүлнэ. Үүнд:

7.1.1. ББСБ-ын оноосон нэр өөрчлөх тухай Хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэр;

7.1.2. Улсын бүртгэлийн албанаас авсан шинэ оноосон нэрийн тодорхойлолт;

7.1.3. ББСБ-ын өөрчлөлт оруулсан дүрэм;

7.1.4. Бусад шаардлагатай баримт материал.

7.2. Хороо ББСБ-ын оноосон нэр солих хүсэлтийг хянаж, оноосон нэрийг өөрчлөх нь

---

ББСБ-ын харилцагчдад сөргөөр нөлөөлөхгүй, төөрөгдүүлэхгүй гэж үзвэл тухайн ББСБ-ын оноосон нэрийг өөрчлөхийг зөвшөөрсөн тухай шийдвэрийг Хорооны дарга гаргана.

7.3.ББСБ-ын оноосон нэрийг өөрчилсөн тухай Хорооны даргын шийдвэр болон Хорооноос баталсан Тусгай зөвшөөрлийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг тогтоох тухай журамд зааснаар холбогдох хураамжийг Хорооны дансанд төлсөн баримтыг үндэслэн Хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хураан авч, шинээр тусгай зөвшөөрлийн гэрчилгээг олгоно.

#### НАЙМ. БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА, БАНК БУС САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ

8.1.Хороо нь банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх зарим тусгай зөвшөөрлийг дараах үндэслэлээр хязгаарлаж, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлнэ. Үүнд:

8.1.1.тухайн үйл ажиллагаа нь ББСБ-ын санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж байна гэж үзсэн;

8.1.2.ББСБ өөрөө хүсэлт гаргасан;

8.1.3.хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.

8.2.Хороо нь банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 13.1-д зааснаас гадна дараах үндэслэлээр түдгэлзүүлнэ. Үүнд:

8.2.1.Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн талаарх шаардлагыг 6 сар дараалан хангаж ажиллаагүй;

8.2.2.ирүүлбэл зохих санхүүгийн тайлан мэдээг 6 сар дараалан Хороонд гаргаж өгөөгүй;

8.2.3.ББСБ-ын дүрмийн сан Хорооноос тогтоосон дүрмийн сангийн доод хэмжээнд хүрээгүй нь шалгалтаар илэрч, улсын байцаагчийн актаар тогтоогдсон;

8.2.4.Хорооноос тогтоосон зохицуулалтын үйлчилгээний хөлс төлөх хугацааг 3-аас дээш сараар хэтрүүлсэн;

8.2.5.хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.

8.3.Хороо Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14.1-т заасан болон дараах үндэслэлээр ББСБ-ын банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно. Үүнд:

8.3.1.ББСБ дампуурсан буюу төлбөрийн чадваргүй болсон эсхүл татан буугдсан тухай эрх бүхий байгууллага болох шүүх, Хороо, хувь нийлүүлэгчдийн хурлаас зарласан;

8.3.2.ББСБ байгуулахдаа хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь улсын бүртгэлд бүртгүүлснээс хойш 1 жилийн дотор илэрсэн;

8.3.3.ББСБ нь улсын бүртгэлд бүртгүүлснээс хойш 1 жилээс дээш хугацаанд үйл ажиллагаа явуулаагүй;

---

8.3.4.Хорооноос баталж гаргасан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн талаарх шаардлагыг 9 сар дараалан хангаж ажиллаагүй;

8.3.5.ирүүлбэл зохих санхүүгийн тайлан мэдээг 9 сар дараалан Хороонд гаргаж өгөөгүй;

8.3.6.тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгах талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй;

8.3.7.хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.

8.4.Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон нөхцөлд Хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хураан авч, хүчингүй тэмдэг даран, тухайн ББСБ-ын хувийн хэрэгт хийж, зохих журмын дагуу архивт шилжүүлнэ.

8.5.Хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тохиолдолд тусгай зөвшөөрлийг дахин олгох тухай ББСБ-ын хувь нийлүүлэгчдийн хүсэлтийг 1 жилийн дотор хүлээн авахгүй бөгөөд тогтоосон хугацааны дараа хүсэлт гаргахдаа энэ журамд заасан шаардлагын дагуу холбогдох баримт бичгийг шинээр бүрдүүлж ирүүлнэ.

8.6.Энэ журмын 8.1, 8.2-т заасан үндэслэлээр банк бус санхүүгийн зарим үйл ажиллагааг эрхлэхийг хязгаарлаж, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлснээс хойш хязгаарласан, түдгэлзүүлсэн шалтгааныг арилгаагүйгээр тухайн үйл ажиллагааг үргэлжлүүлэн эрхэлсэн, эсхүл 6 сарын хугацаанд хязгаарласан тухай шийдвэрийг цуцлах хангалттай нөхцөл бүрэлдээгүй бол тухайн төрлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгоно.

8.7.Хороо нь ББСБ-ын үйл ажиллагаа явуулахаар олгосон зөвшөөрлийг хүчингүй болгосон тохиолдолд энэ тухай олон нийтэд мэдээлнэ.

8.8.Банк бус санхүүгийн зарим үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл болон банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн тохиолдолд түдгэлзүүлсэн үндэслэл болсон зөрчил дутагдлыг арилгаж хэвийн үйл ажиллагаагаа хангасан гэж үзвэл тухайн ББСБ банк бус санхүүгийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг сэргээлгэх хүсэлтийг Хороонд гаргаж болно. Хэрэв хүсэлт гаргаагүй тохиолдолд банк бус санхүүгийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.

#### ЕС. ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛСЭН БОЛОН ХҮЧИНГҮЙ БОЛГОСНООС ҮҮСЭХ ҮР ДАГАВАР

9.1.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосноос тусгай зөвшөөрөл эзэмшигчид учирсан хохирлыг Хороо хариуцахгүй.

9.2.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн тухай мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш ББСБ нь дараах үйлдэл хийхийг хориглоно. Үүнд:

9.2.1.шинээр гэрээ байгуулах;

9.2.2.тухайн өдрөөс өмнө байгуулсан гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах.

---

9.3.Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш ББСБ-д энэ журмын 9.2-д заасан үйлдэл хийхийг хориглох бөгөөд тухайн ББСБ-ыг Банк бус санхүүгийн үйл ажиллагааны болон Компанийн тухай хуульд заасны дагуу татан буулгаж, үйл ажиллагааг нь дуусгавар болгоно.

9.4.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон тухай Хорооны шийдвэр гарснаас хойш уг үйл ажиллагааг үргэлжлүүлбэл тусгай зөвшөөрөлгүйгээр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлсэн гэж үзэж Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

#### АРАВ. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

10.1.Хороо нь энэ журмын биелэлтэд хяналт тавьж, газар дээр шалгалт хийж, холбогдох хууль тогтоомж зөрчсөн этгээдэд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 18.1, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 20.1-д заасан хариуцлага хүлээлгэнэ.

#### САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

БАНК БУС САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ХҮССЭН ӨРГӨДӨЛ

Огноо: .....

Хаана: Санхүүгийн зохицуулах хороо,  
Засгийн газрын IV байр  
Бага тойруу-6,  
Улаанбаатар-46,  
Монгол Улс.

Хэнээс: .....

(*өргөдөл гаргагчийн овог, нэр, хаяг, утас, факс, электрон шуудангийн хаяг*)

.....  
*/банк бус санхүүгийн байгууллагын нэр/* */ХК, ХХК/*

ББСБ-ын үүсгэн байгуулагч /үүсгэн байгуулагч/ шинээр ББСБ үүсгэн байгуулах зорилгоор хурал хийж, дор дурдсан банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэхээр шийдвэрлэсэн болно. Үүнд:

- 1/ .....
- 2/ .....

*/банк бус санхүүгийн үйл ажиллагааны төрөл/*

Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэхэд дараах хуулийн этгээд, хуулийн этгээдийг үүсгэн байгуулагч иргэд тус ББСБ-д хөрөнгө оруулахаар шийдвэрлэв.

Д/д	Овог, нэр <i>/Хуулийн этгээдийн нэр/</i>	Регистрийн дугаар	Иргэний үнэмлэхийн дугаар <i>/Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар/</i>	Хаяг	Хувь нийлүүлэх хөрөнгийн хэмжээ (мянган төгрөгөөр)

ББСБ-ын үүсгэн байгуулагч /үүсгэн байгуулагчид/ нь өөрийн хууль ёсны өмчлөлд байгаа мөнгөн хөрөнгөөр хувь нийлүүлсэн болно.

ББСБ-ын гүйцэтгэх удирлагад /гүйцэтгэх захирал, нэгжийн удирдлага, ерөнхий нягтлан бодогч, дотоод хяналтын ажилтнууд/ Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 13.6-д заасан шаардлагыг хангасан дараах хүмүүс ажиллах болно. Үүнд:

Д/д	Овог, нэр	Одоогийн эрхэлж байгаа ажил	Регистрийн дугаар	Иргэний үнэмлэхийн дугаар	ББСБ-д эрхлэх албан тушаал

Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахаар бүрдүүлж хүргүүлсэн баримт материалуудыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн

тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 05 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын шаардлагад нийцүүлэн үнэн зөв бүрдүүлсэн болно. Бүрдүүлсэн баримт бичигт ямарваа худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг бид хүлээх болно.

Өргөдөл, баримт материалыг хүлээн авч, хянан шийдвэрлэж ББСБ байгуулж, банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгоно уу.

ББСБ байгуулагдсанаас хойшхи хугацаанд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай болон бусад холбогдох хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооноос өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж ажиллах болно.

**ӨРГӨДӨЛ ГАРГАГЧ:**

/...../  
*/гарын үсэг/*

/...../  
*/овог, нэр/*

*Хуулийн этгээд бол:*

*/тамга, тэмдэг/*

.....  
*/хуулийн этгээдийн нэр/*

.....  
*/албан тушаал/*

/...../  
*/гарын үсэг/*

/...../  
*/овог, нэр/*

ББСБ-ЫН ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧИД БОЛОН  
ТУЗ-ЫН ДАРГА, ГИШҮҮДИЙН ТОДОРХОЙЛОЛТ

А. ББСБ-тай ямар холбоотой болохыг тэмдэглэнэ үү.

1. Үүсгэн байгуулагч
2. Нийт хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг эзэмшигч
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн  
дарга   
гишүүн

Б. Үүсгэн байгуулагч /үүсгэн байгуулагчид/-ийн талаар.

1. Үүсгэн байгуулагч нь:

Хуулийн этгээд  Иргэн

2. ББСБ-д хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ:

Энгийн хувьцаа

Давуу эрхтэй хувьцаа

..... /тоогоор/ ..... /үсгээр/ ..... /төгрөг

3. Үүсгэн байгуулагч /хувь нийлүүлэгч/ нь хуулийн этгээд бол дараах мэдээллийг үнэн зөв бичиж ирүүлнэ. Үүнд:

- Оноосон нэр:
- Байгуулагдсан он, сар, өдөр:
- Үйл ажиллагаа эрхлэх хугацаа:
- Байршил буюу хаяг:
- Улсын бүртгэлийн дугаар:
- Регистрийн дугаар:
- ТУЗ-ын дарга, гишүүдийн овог нэр:
- Регистрийн дугаар:
- Хувь нийлүүлэгчдийн овог нэр:
- Регистрийн дугаар:


- Эрхэлж буй үйл ажиллагааны төрөл:
- Хуулийн этгээдийн үйл ажиллагаатай холбогдсон танилцуулга

*/эрхэлж ирсэн үйл ажиллагааг хугацаагаар нь, хараат буюу охин компанитай эсхүл нэгжтэй эсэх, тэдгээрийн болон тухайн байгууллагын үйл ажиллагаа, санхүүгийн үр дүн, байршил, өмчлөлийн байдал, бусад байгууллагад хувь нийлүүлсэн хөрөнгө зэргийг хамруулан бичнэ/.*

- Дүрмийн санг бүрдүүлсэн хөрөнгийн танилцуулга, тодорхойлолт.  
Хуулийн этгээдийн нэр нь ..... ББСБ-ын хувь нийлүүлэгч болж тус ББСБ-ын дүрмийн санд оруулж байгаа ..... / үсгээр ..... / төгрөг нь манай хуулиар зөвшөөрөгдсөн үйл ажиллагаанаас олсон орлогоос бүрдэж байгаа бөгөөд холбогдох материалуудыг үнэн зөвөөр хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэн танайд хүргүүлсэн болохоо нотлохын зэрэгцээ үүнээс үүсэх аливаа эрсдлийг хууль тогтоомжийн дагуу бүрэн хариуцахаа илэрхийлж байна.

4. Үүсгэн байгуулагч нь иргэн бол дараах мэдээллийг үнэн зөв бичиж ирүүлнэ:

- Овог, нэр:
- Төрсөн он, сар, өдөр:
- Иргэний харьяалал:
- Гэрийн хаяг:
- Иргэний үнэмлэхийн дугаар:
- Регистрийн дугаар:
- Эрхэлж байгаа ажил:
  - хугацаа:
  - хаяг:
- Боловсролын талаар */Ерөнхий боловсролын сургуулийг оролцуулан бичнэ/*



Д/д	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он	Диплом, гэрчилгээний дугаар



- Ажлын туршлагын талаар:

Д/д	Хаана ажиллаж байсан	Албан тушаал	Ажилд орсон он, сар, өдөр	Ажлаас гарсан он, сар, өдөр	Шалтгаан

5. Хувь нийлүүлэгчийн холбогдох этгээдийн байдал:

Д/д	Таны юу болох	Овог, нэр /Хуулийн этгээдийн нэр/	Регистрийн дугаар	Иргэний үнэмлэхийн дугаар	Эрхэлж буй албан тушаал

.....овогтой ..... миний бие ..... ББСБ-ын хувь нийлүүлэгч болж тус ББСБ-ын дүрмийн санд оруулж байгаа ..... /..... үсгээр...../ төгрөг нь миний хуулиар зөвшөөрөгдсөн үйл ажиллагаанаас олсон орлогоос бүрдэж байгаа бөгөөд холбогдох материалуудыг үнэн зөвөөр хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэн танайд хүргүүлсэн болохоо нотлохын зэрэгцээ үүнээс үүсэх аливаа эрсдлийг хууль тогтоомжийн дагуу бүрэн хариуцахаа илэрхийлж байна.


*Холбогдох этгээдийн товч танилцуулгад урьд өмнө эрхэлж байсан ажил, төрлийн байдал, аль нэг хуулийн этгээдийг төлөөлдөг эсэх, түүний үйл ажиллагаа, байршил, бусдад өр, зээлтэй эсэх, одоо хууль хяналтын байгууллагад хэрэг үүсгэгдэн шалгагдаж байгаа эсэх зэргийг бичнэ.*

..... ББСБ-ыг төлөөлж ..... /албан тушаал/  
 /..... /гарын үсэг/ /..... /овог, нэр/

ББСБ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ, НЭГЖИЙН УДИРДЛАГА  
БОЛОН БУСАД БОЛОВСОН ХҮЧНИЙ ТОДОРХОЙЛОЛТ

6. ББСБ-ын гүйцэтгэх захирал, нэгжийн удирдлага бусад боловсон хүчин нь дараах мэдээллийг үнэн зөв бичиж ирүүлнэ:

- овог, нэр:
- эрхлэх албан тушаал:
- төрсөн он, сар, өдөр:
- иргэний харьяалал:
- гэрийн хаяг:
- утасны дугаар:
- иргэний үнэмлэхийн дугаар:
- регистрийн дугаар:
- одоо эрхэлж байгаа ажил:
  - хугацаа:
  - хаяг:
    - Боловсролын талаар /Ерөнхий боловсролын сургуулийг оролцуулан бичнэ/



Д/д	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он	Диплом, гэрчилгээний дугаар

▪ ажлын туршлагын талаар:

Д/д	Хаана ажиллаж байсан	Албан тушаал	Ажилд орсон он, сар, өдөр	Ажлаас гарсан он, сар, өдөр	Шалтгаан

▪ гүйцэтгэх удирдлага, боловсон хүчний товч танилцуулга (аль нэг хуулийн этгээдийг төлөөлдөг эсэх, түүний үйл ажиллагаа, байршил, банк, ББСБ-тай харьцаж байсан түүх, харилцагч банкууд, өөр аль нэг хуулийн этгээдийн хувь нийлүүлэгч эсэх, бусдад өр, зээлтэй эсэх одоо хууль хяналтын байгууллагад хэрэг үүсгэгдэн шалгагдаж байгаа эсэх зэргийг бичнэ):

2. Гүйцэтгэх удирдлага, боловсон хүчний холбогдох этгээдийн байдал:

Холбогдох этгээд гэдгийг Банкны тухай хуулийн 3 дугаар зүйлд тодорхойлсноор ойлгоно.

Д / д	Таны юу болох	Овог, нэр	Регистрийн дугаар	Иргэний үнэмлэхийн дугаар	Эрхэлж буй албан тушаал

*Холбогдох этгээдийн товч танилцуулгад урьд өмнө эрхэлж байсан ажил, төрлийн байдал, аль нэг хуулийн этгээдийг төлөөлдөг эсэх, түүний үйл ажиллагаа, байриил, бусдад өр, зээлтэй эсэх, одоо хууль хяналтын байгууллагад хэрэг үүсгэгдэн шалгагдаж байгаа эсэх зэргийг бичнэ.*

*Гүйцэтгэх удирдлага боловсон хүчний талаарх хууль хяналт, татвар, аудит, банк болон бусад холбогдох хуулийн этгээд, байгууллага, иргэдээс гаргуулан авсан тодорхойлолт, лавлагаа зэргийг хавсаргав.*

..... ББСБ-ыг төлөөлж .....  
/албан тушаал/  
/..... / /..... /  
/гарын үсэг/ /овог, нэр/

ПРОГРАММ ХАНГАМЖ, ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ,  
АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ

ББСБ-ын үйл ажиллагаанд ашиглах техник, тоног төхөөрөмжийг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

Д/д	Техник, тоног төхөөрөмжийн төрөл	Техникийн үзүүлэлт	Худалдан авсан, түрээслэсэн алин болох	Тоо ширхэг

ББСБ нь дээрх тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, компьютерээс гадна нягтлан бодох бүртгэлийн . . . . .  
(программ, түүнийг зохиосон байгууллагын нэр) программ, зээлийн мэдээллийн санд мэдээ өгч, авах зориулалт бүхий . . . . . (программ, түүнийг зохиосон байгууллагын нэр) программ, болон . . . . .  
. . . . . –Г. . . . .  
(худалдан авсан, худалдан авах гэж байгаа эсхүл гэрээ хийсэн байгаа аль нь эсэхийг бичих) бөгөөд өдөр тутмын мэдээ, мэдээлэл боловсруулалтын ажилд компьютерийн . . . . . (программ, түүнийг зохиосон байгууллагын нэр) программ ашиглах болно.

ББСБ нь үйл ажиллагаа явуулах байрыг:

- худалдан авсан
- түрээслэсэн

бөгөөд энэхүү байр нь ББСБ-ын үйл ажиллагаа эрхлэхэд тохиромжтой, аюулгүй байдлын хувьд бүрэн хамгаалагдсан болно.

- Худалдан авсан байрны үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн гэрчилгээ
- Түрээслэсэн байрны түрээсийн гэрээ
- Харуул хамгаалалтын асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар тайлбар

. . . . . ББСБ-ыг төлөөлж . . . . .  
/албан тушаал/  
/ . . . . . / / . . . . . /  
/гарын үсэг/ /овог, нэр/

## БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨМЖ

1. Бизнес төлөвлөгөө гэдэг нь ББСБ-ын стратеги, зорилтыг тодорхойлж, банк бус санхүүгийн үйл ажиллагааг эрхлэхэд түүний бүтэц, зохион байгуулалт, үйлчилгээний шуурхай, найдвартай ажиллагаа, удирдлагын ур чадвар, санхүү, төлбөрийн чадварын үзүүлэлт, үр ашгийг жил тутам сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой цаг хугацаагаар төлөвлөн боловсруулсан баримтыг хэлнэ.

2. ББСБ нь бизнес төлөвлөгөөг өөрийн үйл ажиллагааны онцлогтой уялдуулан боловсруулах бөгөөд дараахь асуудлуудыг заавал тусгасан байна. Үүнд:

- 2.1. банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх зорилго, баримтлах бодлого, ББСБ-ын хэтийн төлөв байдал;
- 2.2. банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэхэд ашигтай байх макро болон микро түвшин дэхь боломжит нөхцөлүүд;
- 2.3. ББСБ-ын тайлан тэнцэл, мөнгөн хөрөнгийн урсгал, орлого зарлагын 3-5 жилийн төсөөлөл;
- 2.4. актив, пассивын бүтэц, хэмжээ түүний удирдлагыг сайжруулах төлөвлөгөө, хүү, шимтгэлийн ерөнхий нөхцөлүүд, энэ талаар баримтлах бодлого;
- 2.5. үйл ажиллгатай холбогдон гарах эрсдлийг тодорхойлж, түүнийг удирдахад авах арга хэмжээ.

3. Бизнес төлөвлөгөөг банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэн явуулж эхэлснээс хойш 3-5 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөн боловсруулна.

4. Бизнес төлөвлөгөө нь дараах хэсгээс бүрдэнэ. Үүнд:

### Нүүр хуудас

Бизнес төлөвлөгөөний нүүр хуудсанд дараах зүйлсийг тусган харуулна:

- ББСБ-ын нэр, хаяг
- Бизнес төлөвлөгөөний нэр
- Хувилбарын дугаар
- Боловсруулсан огноо
- Зохиогчийн нэр, хаяг
- Зохиогчийн тэмдэглэл
- ББСБ-ын удирдлагын нэр, хаяг

### 1. ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААНГУЙ

Энэ бүлэгт тухайн бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэгч ББСБ-ын тухай, хэрэгжүүлэх гэж буй бизнес төлөвлөгөөний эрхэм зорилго, зорилт, амжилтын үндэс, учирч болох эрсдэл болон санхүүгийн бусад үзүүлэлтүүдийн тухай товч мэдээллийг багтаана.

Эрхэм зорилго гэдэг нь хэний ямар хэрэгцээг, яаж хангах тухай тодорхойлолт юм.

Зорилт гэдэг нь эрхэм зорилтонд хүрэхийн тулд шат дараалан хэрэгжүүлэх, хугацаатай, хэмжигдэхүйц бодитой үр дүн буюу хүрэх цэг юм.

---

## 2.БИЗНЕСИЙН ТАНИЛЦУУЛГА

Бизнесийн танилцуулга гэдэг нь тухайн ББСБ-ын нэр, хаяг, өсөж хөгжиж ирсэн түүх, хариуцлагын тогтолцоо, зах зээлийн нөхцөл төлөв байдал, эрхэлж байгаа үйл ажиллагаа, гаргаж буй үйлчилгээ түүнчлэн удирдлага боловсон хүчний хангалт, санхүүгийн чадавхи ба байдал бизнес төлөвлөвлөгөө бичих болсон шалтгаан, зорилго зорилтууд түүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр,зээлийг эргэж төлөх хугацаа, үр ашиг, борлуулалтын орлого, ашиг зэргийг тусган харуулсан хураангуй тодорхойлолт юм.

Бизнесийн танилцуулга нь дараах үндсэн хэсгүүдээс бүрдэнэ:

- Бизнес ба түүний түүх
- Зах зээлийн нөхцөл төлөв байдал
- Одоо явуулж байгаа үйл ажиллагаа
- Удирдлага боловсон, хүчин
- Санхүүгийн байдал төлөв
- Бизнес төлөвлөгөө бичих болсон шалтгаан, зорилго

## 3.МАРКЕТИНГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Бизнес төлөвлөгөөний “маркетингийн төлөвлөгөө”-г дараахи гурван хэсэг дээр бичнэ ҮҮ.

### 3.1.Зах зээлийн шинжилгээ

Маркетингийн төлөвлөгөөг боловсруулахын тулд юуны түрүүнд зах зээл буюу хэрэглэгчдийнхээ тухай судалж мэдэх, зах зээлийг тань булаацалдах өрсөлдөгчид, танайд бараа үйлчилгээ үзүүлэх түншүүд, зуучлагчдынхаа талаар судлах ёстой.

### 3.2.Маркетингийн стратеги

Маркетингийн стратеги гэдэг нь зах зээл рүү хандсан төлөвлөгөө буюу амжилт олохын тулд танай байгууллагын хэрэглэж буй арга замууд юм.

### 3.3.Маркетингийн иж бүрдэл

Танай байгууллага зах зээл рүүгээ хандах арга зам буюу стратегиа тодорхойлсон бол одоо зах зээл дээр таатай байдал үүсгэхийн тулд байгууллагын ашигладаг хүчин зүйлс буюу маркетингийн иж бүрдлийг хэрхэн бүрдүүлэх вэ? Маркетингийн иж бүрдэлд үйлчилгээ, үнэ, идэвхжүүлэлт, хуваарилалтын талаар тусгана.

## 4. МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Бизнес төлөвлөгөөний энэ бүлэгт удирдлага, зохион байгуулалт, боловсон хүчний хэрэгцээ гэсэн асуудлуудыг багтааж оруулна.

Удирдах баг: Бизнес төлөвлөгөөний энэ хэсэгт удирдах багийн гишүүд нь банк санхүү, менежментийн чиглэлээр хэр мэргэшсэн, бие биенээ орлох чадвар нь ямархуу болох, мэргэжил дадлага туршлагатай байх шаардлагыг хэр зэрэг хангасан байдал болон эрх мэдэл, ажил үүргийг оновчтой хуваарилсан байдал зэргийг харуулах хэрэгтэй. Удирдах багийн болон мэргэжилтэн (хуулийн зөвлөх г.м.), тэргүүлэх ажилтны (салбаруудын удирдлага г.м.) дадлага, туршлага, тухайн салбарт ажилласан байдал, үүрэг хариуцлага зэрэг тухайн ажил үүргийг гүйцэтгэхэд шаардагдах мэдээлэл бүхий намтрыг бизнес төлөвлөгөөндөө хавсаргах шаардлагатай. Түүнчлэн удирдах багийн гишүүн бүрийн эрх үүрэг хариуцлагыг нягт тогтоож, хэн нь хэнд захирагддаг, хэн эцсийн шийдвэр гаргагчийг зааж байгууллагын дүрэмд оруулан баталгаажуулж, төлөвлөгөөндөө

---

хавсаргаж болно.

Зохион байгуулалтын бүтэц: Удирдах багийн дор зохион байгуулалтын шат дамжлага багатай, хамгийн үр ашигтай бүтцийг тогтоох нь чухал. Цөөн хүнтэй хамт олны зохион байгуулалтын бүтцийн үр ашигтай байх үндэс зарчим нь нэг удирдлагатай байх, ажил үүргийг оновчтой хуваарилах, удирдагч мэдээллээр сайн хангагддаг байх, ажиллагчид ажлынхаа үр дүнг сонирхдог байх, хяналт ил тод байх явдал болно. Энэхүү зарчмыг баримтлан зохион байгуулалтын бүтцээ тогтоож бизнес төлөвлөгөөндөө оруулна.

Боловсон хүчин: Энэ хэсэгт шаардагдлагатай мэргэжлийн боловсон хүчин тэдгээрийн тоо түүнчлэн мэргэжил эзэмшүүлэх эсвэл мэргэжил дээшлүүлэх сургалтын асуудлуудыг төлөвлөх болно.

Энэ хэсэгт нийт ажиллагчид болон шаардлагатай мэргэжлийн боловсон хүчний хэрэгцээ, уг ажлыг гүйцэтгэх ажиллагсдын тоо түүнчлэн нийт ажиллагсдын сар, жилийн цалингийн хэмжээ, цалингийн шимтгэлийг тооцоолж төлөвлөнө.

Сургалтанд зориулсан зардал хэдийгээр гаднаас нь харахад ашиггүй мэт боловч үр ашгаа зүй ёсоор өгдөг гэдгийг анхаарвал зохистой.

## 5. САНХҮҮГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Санхүүгийн төлөвлөгөөнд дараах хэсгүүд орно. Үүнд :

- Нийт орлогын тооцоо
- Үйл ажиллагааны урсгал зардлын тооцоо
- Ашиг/ алдагдлын тооцоо
- Алдагдалгүй ажиллагааны тооцоо
- Мөнгөн урсгалын тооцоо

орно.

## 6. ЭРСДЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ

### 6.1. Эрсдэлийн төрлүүд:

Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэхэд 4 төрлийн үндсэн эрсдэлийг тооцоолоход болно. Үүнд:

- Техник, тоног төхөөрөмжийн
- Санхүүгийн буюу зээлийн
- Хүний хүчин зүйлийн
- Хууль зүйн

### 6.2. Эрсдэлийг багасгах боломжууд

Эдгээр дурьдсан эрсдэлээс чухам ямар нь танай бизнест тохиолдож болох магадлал илүү вэ? Түүнийг доод хэмжээнд байлгахын тулд та ямар арга хэмжээ төлөвлөснөө бичих нь зүйтэй. Дараа нь даатгалд хамруулж болох эрсдэлийг ангилж ямар нөхцлөөр аль даатгалын компанитай гэрээ хийхээ тодорхойлж бич. Харин даатгалд үл хамаарах эрсдэлийн талаар авах арга хэмжээг хэрхэн төлөвлөж байгааг тодорхойлох шаардлагатай.

Эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсны дүнд ББСБ-ын ашигт ажиллагаа хэрхэн хадгалагдаж үлдэхийг төлөвлөсөн үр дүнтэй жишиж харьцуулаарай.